



ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

᠒᠐᠒᠐ оны 11 сарын 27 өдөр

Дугаар 110

Эрдэнэт


2021 онд ойгоос түлшний мод  
бэлтгэх дээд хэмжээг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Байгаль хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2 дахь заалт, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэг, Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2020 оны А/599 дүгээр тушаалыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн 2018 оны ойн зохион байгуулалтын ажлын тайлан, ойн менежмент төлөвлөгөөг харгалзан 2021 онд аймгийн хэмжээнд ойгоос бэлтгэх модны дээд хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Холбогдох хууль тогтоомж, журмын дагуу ойгоос бэлтгэх модны төрөл, тоо хэмжээг нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага тус бүрээр тогтоохыг Баян-Өндөр сум, Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тус тус зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.МӨНХБАТ